

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
/2019-2020 ОН/

АУДИТЫН КОД:
АРА-2021/52/-ШТА-ГА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азхүү

Цахим хаяг: azkhuub@audit.gov.mn

аудитор П.Цэцэгдулам, Ж.Мөнгөншагай

Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2021 ОН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор Б.Азхүү Аудитор П.Цэцэгдулам, Ж.Мөнгөншагай 2021 оны 09 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ 1. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙХГҮЙ НЬ ХУУЛЬ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ ГОЛ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА. <i>Зорилт 1.1 Аймгийн ИТХ нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.</i> <i>Зорилт 1.2 Аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.</i> БҮЛЭГ 2. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ, БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА. <i>2.1 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.</i> <i>2.2 Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжгүй тул төлбөрийг хуулийн дагуу ногдуулж, төвлөрүүлэх боломжгүй байна.</i> БҮЛЭГ 3. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. <i>Зорилт 3.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</i> <i>Зорилт 3.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.</i> Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТТАМТХ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
АМХТЗТ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
АМАТЗТ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
БОУБ	<i>Байгаль орчны улсын байцаагч</i>



АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/28 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж, ногдуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, дүнг шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд танилцуулж, санал, зөвлөмж боловсруулан, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгосон эсэх
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн төлөвлөлт, бүрдүүлэлт нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ХОХБТХ, СТСХ, ГХБХБГ, БОАЖГ, МХГ зэрэг байгууллагуудаас гадна түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрүүд, төлбөрийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой 2019-2020 оны баримт материалыг хамруулан шалгав.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудитын тулгуур зарчим MNS 6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан **“Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам,”** МУЕА-ын 2021 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан **“Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг** баримтлан аудитын төлөвлөгөөний арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, тайлбар тодруулга, асуулга авах, түүвэр хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллалаа.



АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг Аудитын менежер Д.Нэргүйбаатар хэрэгжүүлж, Ахлах аудитор Б.Азхүү, аудитор П.Цэцэгдулам, Ж.Мөнгөншагай нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхай эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль 2014 оны 01-р сарын 09-ний өдөр батлагдан, хэрэгжиж эхэлснээс хойш нийт 4 удаа өөрчлөлт орсон байна.

Аудитын төлөвлөлтийн өмнөх шатанд цуглуулсан баримт материалаас үзэхэд Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл сүүлийн жилүүдэд олгогдоогүй байна. Харин 2005 онд Төвшрүүлэх суманд “Өнгөт тулга” хоршоо, 2018 онд Чулуут суманд “Бармаат гарам” зэрэг ААН-үүдэд хүрмэн чулуу ашиглах зөвшөөрөл олгосон боловч өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон ашиглаж байгаа талбай, ААН-ийн талаарх нэгдсэн судалгаа, мэдээлэлгүй байна.

Хуулийн 33.1-д “Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө” гэж заасан. Архангай манай аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд тусгай зөвшөөрөл олгоогүй байна. Харин түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсөвт 2019 онд 57.6 сая төгрөг, 2020 онд 58.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.



БҮЛЭГ 1. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН БОЛОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙХГҮЙ НЬ ХУУЛЬ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ ГОЛ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.

1.1 Аймгийн ИТХ нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1.1 Холбогдох хуульд¹ заасны дагуу аймгийн ИТХ-ын тогтоолоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталдаг. 2019, 2020 оны аймгийн ИТХ-аар баталсан “Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө түүний биелэлтийн баримт материалыг шалгахад Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй бөгөөд Аймгийн газар зохион байгуулалтын 2006-2021 оны ерөнхий төлөвлөгөөнд ч мөн тусгагдаагүй байна.

Дээрх байдлаас үзэхэд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хуулийн 11.1.1-т “*аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах*” гэсэн бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 2006-2021 оны хооронд хэрэгжиж, дуусах хугацаатай бөгөөд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчлэх ажлыг 2022 онд бүрэн дуусгаж, батлуулах чиглэлийг Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар даалгасан байна.

1.1.2 Аймгийн ИТХ-ын 2019-2020 оны тогтоол, сумдаас ирүүлсэн судалгааг нэгтгэн үзэхэд Батцэнгэл, Ихтамир, Тариат сумын ИТХ-аас бусад аймаг, сумын ИТХ түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан тогтоол, шийдвэргүй нь хуулийн 11.1.2-т “*Газрын тухай хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах*” гэж заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ талаар аймгийн ИТХ-ын ажлын албанаас тодруулахад “тусгай хэрэгцээнд авсан шийдвэр гараагүй” гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлээд байна. /аймгийн ИТХ-ын 2021.09.03-ны өдрийн 97 тоот албан бичиг/

Иймд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг тусгаж батлах, ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарган хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

1.2 Аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

1.2.1 Аймгийн хэмжээнд 2019, 2020 онд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна. 2019 оны 6 дугаар сард Хорго

¹ Газрын тухай хуулийн 20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрх

20.1.2. тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;



өргөө ХХК-аас аймгийн Засаг даргад Тариат сумын Бөөрөлжүүт багийн нутаг дэвсгэрт Цагаан уул нэртэй газарт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл ирүүлсэн байна. Уг өргөдөлд Ашигт малтмал, газрын тосны газраас Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3²-т заасны дагуу 2020.08.17-ны өдрийн 8/3697 тоот албан бичгээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэсэн дүгнэлтийг аймгийн Засаг даргад ирүүлсэн байна. Аймгийн Засаг даргаас хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-дэх заалтын дагуу Тариат сумын Засаг дарга, ИТХ-ын даргад уг асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх албан бичгийг 2020.09.09-ний өдөр хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна. Энэ талаар Тариат сумын ИТХ-аас тодруулахад аймгийн Засаг даргын 2020.09.09-ны өдрийн 01/1009 тоот бичиг албан ёсоор ирээгүй, “Цагаан уул”-ын хүрмэн чулууг аймаг, сумын хэмжээнд иргэдийн хүсэлтийн дагуу ашиглаж байгаа гэсэн тайлбарыг өглөө. /Тариат сумын ИТХ-ын даргын 2021.10.01-ны өдрийн 25 тоот бичиг/

1.2.2 Аймгийн хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байхгүй нь хууль хэрэгжихгүй байх гол шалтгаан болж байна.

1.2.3 Аймгийн Засаг даргын 2014.05.21-ний өдрийн А/281 тоот захирамжаар “Аймгийн төв, сумын барилгын материалын зориулалтаар ашиглагдаж байгаа орд газрын байршлыг тогтоох тухай” нийт 49 судлагдсан орд газар бүхий байршлаас орон нутагт барилгын материалд ашиглагддаг элбэг тархалт бүхий элс хайрга, дайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин чулууг ашиглуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Аудитын явцад сумдаас авсан судалгаанаас үзэхэд судлагдсан 49 байршлын 90 орчим хувь нь ашиглагдаагүй, шинээр карьер үүсгэн зөвшөөрөлгүй олборлож, ашиглаж байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно”, Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж заалттай нийцэхгүй байна.

Аудитын баг зөвшөөрөлгүй ашиглагдаж, олборлож байгаа томоохон элс, хайрга, хүрмэн чулууны карьерууд дээр очиж үзэхэд ямарч нөхөн сэргээлт хийгдээгүй, зарим карьер нь хогоор дүүрсэн, эгц босоо хана, саравч үүссэн байдалтай байлаа.

² ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасан талбайд тусгай зөвшөөрөл олгох боломжтой эсэх талаар дүгнэлт гаргаж Засаг даргад хүргүүлэх”



Тариат сумын Бөөрөлжүүт багт байршилтай “Цагаан уул”-ын хүрмэн чулууны орд газар /2021.10.01/



Булган сумын “Авхайн булаг”-ийн хайрга, “Цагаан хаалга”-ны улаан шорооны карьер /2021.09.22/



Эрдэнэбулган сумын “Авхайн булаг”-ийн хайрга, 5-р багт байршилтай ээзгий хайрганы карьер /2021.09.22/



“Авхайн булаг”-ийн хайрганы карьер нь Эрдэнэбулган, Булган нутаг дэвсгэрийг хамран байршдаг бөгөөд 2 сумын хооронд хилийн зэсийн маргаантай байдаг байна.



Ихтамир сумын Тайхар багт байршилтай хайрга,элсний карьер /2021.09.27/



Өндөр-Улаан сумын Баянгол багт байршилтай замын шорооны карьер
/2021.09.29/



Эрдэнэбулган сумын 7-р багт байршилтай Автозам ХХК, Цагаан сүмбэр ХХК-ний
хайрганы бутлуур /2021.09.22/



Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүй олборлож ашиглаж байгаа нийтлэг зөрчлийг таслан зогсоож, хуульд нийцүүлэн холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.



БҮЛЭГ 2. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ, БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

2.1 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.

2.1.1 2014 оноос өмнө түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон ашиглах, төлбөрийн хэмжээг тогтоох үйл ажиллагаа нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдаж байсан бөгөөд хуулийн 47¹ дугаар зүйлийн 47^{1.3}-т заасны дагуу 2006 онд аймгийн ИТХ-аар 15 нэр төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтоосон байна. Харин 2014 оноос хойш тухайн үйл ажиллагаа нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдах болсноор төлбөрийн хэмжээг хуулийн 33.2-т "ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна" гэж заасан. Аймгийн хэмжээнд хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжгүй нь хуульд заасан 2.5 хувиар төлбөр тогтоох боломжгүй юм. Харин түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-ын 2006 оны 06 сарын 22-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан жишиг хэмжээгээр төлбөрийг тооцож ногдуулан орон нутгийн төсөвт төвлөрүүлсээр байгаа нь хуулийн заалттай зөрчилдөж байна.

Аймгийн ИТХ-ын 2006 оны 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-1

Төлбөр ногдох түгээмэл тархацтай байгалийн баялгийн нэр	Хэмжих нэгж /м3/	Төлбөрийн хэмжээ /төгрөг/	
		ААНБ	Иргэдэд
Тоосгоны шавар	м3	1200	600
Барилгын чулуу	м3	1500	750
Элс	м3	1500	750
Хайрга	м3	1600	800
Шохойн чулуу	м3	3000	1500
Хүрмэн чулуу	м3	2500	1250
Хар шороо	м3	1200	600
Зос будгийн түүхий эд	м3	2000	1000
Шар шавар	м3	1100	550
Боржин болон бусад магмын чулуулаг	м3	2000	1000
Хувирмал чулуулаг	м3	1200	600
Занар	м3	2500	1250
Хужир	Тн	1500	750
Шүү	Тн	4000	2000
Давс	Тн	4000	2000



2.1.2 Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 2019 онд 57.6 сая төгрөг буюу 230 хувиар, 2020 онд 58.2 сая төгрөг буюу 174 хувиар тус тус давж биелсэн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын төлөвлөлтийг сумдын төсвийн төслөөс үзэхэд ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тооцсон бодит тооцоо, суурь судалгаа байхгүй урьд оны гүйцэтгэлд дүйцүүлэн төлөвлөж иржээ.

Аудитын явцад 19 сумын удирдлагууд болон татварын байцаагч, байгаль орчны улсын байцаагч нартай цахимаар холбогдон ярилцлага хийхэд төлбөрийн орлогын төлөвлөлтийн суурь судалгаа тооцоо байхгүй, урьд оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг, зарим суманд аймгаас төлбөрийн орлогыг шууд төлөвлөж өгдөг, бид тооцоолол хийдэггүй” гэсэн тайлбарыг өгч байлаа. Эндээс үзэхэд аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын төлөвлөлтийн талаар татварын суурь тооцоо судалгаа байхгүй, зөвхөн урьд оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад"* баримтлах зарчим, 31 дүгээр зүйлийн 31.4 *"Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. /СТСХ болон Татварын хэлтсийн албан бичиг, сумдтай цахим уулзалт хийсэн бичлэг/

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Татварын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдээс тодруулахад *"өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг"* бөгөөд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажлаас шалтгаалан төлөвлөгөөг бага хэмжээгээр нэмэгдүүлдэг гэсэн тайлбарыг өгч байлаа.

Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг суурь тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөлтийг хийхэд анхаарч ажиллах зөвлөмжийг БОАЖГ-т хүргүүлэв.

2.2. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байхгүй тул төлбөрийг хуулийн дагуу ногдуулж төвлөрүүлэх боломжгүй байна.

2.2.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33.2-т "Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна" гэж заасан. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байхгүй тул хэрэглэгчээс ИТХ-ын 2006 оны 09 дүгээр тогтоолоор тогтоосон тарифаар тооцож төлбөрийн орлогыг бүрдүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2019, 2020 онуудад ойролцоогоор нийт элс 7360.6 м³, хайрга-51376.55 м³, хүрмэн чулуу 11171.6 м³, хар шороо-13900 м³ -ыг ашиглаж төсөвт 115.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.



2019, 2020 оны сумдын түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-2

Сумын нэрс	2019 он			2020 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Ихтамир	2,040.0	1,860.0	180.0	1,380.0	1,010.0	370.0
Чулуут	1,000.0	1,117.0	(117.0)	855.0	3,418.6	(2,563.6)
Хангай	800.0	800.0	-	1,090.0	8,216.2	(7,126.2)
Тариат	2,950.0	8,483.0	(5,533.0)	3,120.0	4,444.0	(1,324.0)
Өндөр-Улаан	900.0	3,773.8	(2,873.8)	545.0	876.8	(331.8)
Эрдэнэмандал	1,200.0	2,418.6	(1,218.6)	1,390.0	8,084.6	(6,694.6)
Жаргалант	900.0	900.0	-	930.0	930.0	-
Цэцэрлэг	810.0	1,047.0	(237.0)	385.0	633.4	(248.4)
Хайрхан	1,760.0	1,512.0	248.0	385.0	385.0	-
Батцэнгэл	205.0	216.0	(11.0)	930.0	930.1	(0.1)
Өлзийт	670.0	691.0	(21.0)	1,250.0	1,988.0	(738.0)
Өгийнуур	400.0	1,116.0	(716.0)	264.0	266.0	(2.0)
Хашаат	214.0	340.0	(126.0)	200.0	200.0	-
Хотонт	860.0	3,589.4	(2,729.4)	776.0	901.2	(125.2)
Цэнхэр	980.0	980.0	-	390.0	390.0	-
Төвшрүүлэх	1,010.0	20,150.0	(19,140.0)	15,474.0	20,000.0	(4,526.0)
Булган	4,121.0	4,230.0	(109.0)	1,250.0	2,240.0	(990.0)
Цахир	360.0	-	360.0	280.0	280.0	-
Эрдэнэбулган	3,820.0	4,435.7	(615.7)	2,510.0	2,970.6	(460.6)
Нийт	25,000.0	57,659.5	(32,659.5)	33,404.0	58,164.5	(24,760.5)

Судалгаанаас харахад 2019, 2020 онуудад Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 13 суманд төлөвлөснөөс 105-1995 хувиар давж биелсэн бол Ихтамир суманд тасарсан байна.

Аудитын дүн шинжилгээний горимын хүрээнд 2019, 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 12 ТАХ-г түүвэрлэн нийт төсөвт өртгийн материалын тооцооноос шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын хэмжээг гарган аймгийн ИТХ-аар тогтоосон төлбөрийн жишиг тарифаар тооцож үзэхэд ойролцоогоор **35.1** сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх тооцоо гарч байна. Үүнийг холбогдох сумдын төсөвт төвлөрүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд 5 аж ахуй нэгжээс **4.3** сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь төрийн сангийн дансны хуулгаар нотлогдож байна. Эндээс үзэхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын төвлөрүүлэлт бүрэн төвлөрдөггүй байдал ажиглагдлаа. Тухайлбал: Сүүлийн жилүүдэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж байгаа бөгөөд 2019 онд 121,010.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 ТАХ, 2020 онд 152,409.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 77 зам, барилга байгууламж, их засварын ажил хийгдсэн байхад тэдгээрийн ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгаа, тооцоо байхгүй байна. Мөн Эрдэнэбулган суманд 2019, 2020 онд 9,250.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 хувийн орон сууц



баригдаж ашиглалтад оржээ. Эдгээр барилгад ашиглагдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг ногдуулж төвлөрүүлсэн эсэхийг Эрдэнэбулган, Булган сумын БОУБ, байгаль хамгаалагч нараас тодруулахад *“хувийн компаниуд бидэнд төлбөр төлдөггүй, хайрганы бутлууртай хувь хүнээс хайргаа авдаг тухайн хүнтэй төлбөр тооцоогоо хийдэг”* гэсэн аман тайлбарыг өгч байлаа. Харин хувийн орон сууцны гүйцэтгэгч компанийн удирдлагуудаас утсаар тодруулахад дээрхтэй адил тайлбарыг өгсөн.

Сумдын БОУБ-ийн 2019, 2020 оны жилийн эцсийн ажлын тайланг авч үзэхэд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтад хэрхэн хяналт тавьсан, тухайн жилд хэдий хэмжээний ашигт малтмал олборлож, ашигласан талаар бичигдсэн зүйлгүй зөвхөн төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тайланд бичсэн байгаагаас үзэхэд сумдын БОУБ-ийн түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын байдалд тавих хяналт сул байгааг харуулж байна.

2.2.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай зөвшөөрөл аймгийн хэмжээнд олгогдоогүй хэдий ч сумд аймгийн ИТХ-аас 2006 онд тогтоосон хэмжээгээр тооцож ашигт малтмалын төлбөрийн орлогыг төвлөрүүлж байна. Харин Булган, Өгийнуур, Төвшрүүлэх, Жаргалант, Хашаат, Цахир зэрэг сумын холбогдох албан тушаалтнууд иргэн аж ахуй нэгжийн үнийн дүнг тогтоолд тусгагдсан дүнгээс зөрүүтэй тооцсон байна.

Орон нутгийн барилгын материалын гол түүхий эд болсон хүрмэн чулууны төлбөрийн хэмжээг Тариат сум ИТХТ-ийн тогтоолоор 3 удаа өөрчилжээ. *Тухайлбал:* 2014.05.02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор нэг м.куб хүрмэн чулууны төлбөрийг гадагш тээвэрлэхэд 5000 төгрөг, суманд ашиглахад 2500 төгрөг, 2018.05.30-ны өдрийн 18 дугаар тогтоолоор гадагш тээвэрлэхэд 6500 төгрөг, суманд ашиглахад 2500 төгрөг, 2020.04.15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор 1000 төгрөг болгож бууруулан баталсан байна. Гэтэл аймгийн төвд ирж зарагдаж байгаа нэг м.куб хүрмэн чулууны зээлийн үнэ дунджаар м3 нь 30.0-35.0 мянган төгрөг байна. /хувиараа блок үйлдвэрлэгч иргэдээс тодруулсан үнийг эх сурвалж болгов/

БҮЛЭГ 3. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх болон ашиглах тусгай зөвшөөрөл олгох аймгийн Засаг даргын шийдвэр 2019, 2020 онд гараагүй хэдий ч зөвшөөрөлгүй ашиглаж олборлож байгаа үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга болон Байгаль орчин аялал жуулчлалын газраас хяналт хэрэгжүүлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй, тодорхойгүй байна.

3.1.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын байдалд хяналт хийгдээгүй байна.



3.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүйгээр ашиглаж, олборлож байгаа иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.

3.2.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д заасны дагуу аймгийн МХГазраас түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын байдалд 2020 онд тандалт судалгаа хийсэн байна. Тандалт судалгаагаар Аймгийн Засаг дарга хуулиар хүлээсэн бүрэн эрхийнхээ хүрээнд аймагт ашиглагдаж буй орд газруудад түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох хүсэлтийг хүлээн авч тусгай зөвшөөрлийг олгоогүй, хүрмэн чулууны орд газраас олборлолт явуулсны улмаас эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийлгээгүй, хууль бусаар орд газар ашиглаж байгаа байдалд орон нутгаас хяналт тавьдаггүй зэрэг зөрчлүүд илэрчээ. Тухайн зөрчил дутагдалд МХГазраас аймгийн Засаг даргад 2021 оны 2 дугаар сард хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай албан тоот, 2021 оны 3 дугаар сард 03-05-017/18 тоот зөвлөмжийг хүргүүлсэн байна. Уг албан бичиг, зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргаас 2021 онд хэрэгжүүлсэн ажлын талаар ХОХБТХ-ийн мэргэжилтэнтэй уулзалт хийж холбогдох тайлбарыг авахад зөвлөмж, албан тоотын дагуу аймгийн Засаг даргад 2021 онд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 5 өргөдөл ирснийг ашигт малтмал, газрын тосны газрын бүртгэлийн цахим системд шивсэн. Харин “Цагаан сүмбэр” ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэсэн хариу ирүүлсэн бөгөөд ТТАМТХ-ийн 14.4-т³ заасны дагуу сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж санал авахаар албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна гэсэн тайлбарыг өглөө.

Аймгийн МХГазар нь Тариат сумын хүрмэн чулууны олборлолт ашиглалтаас бусад сумдын түгээмэл тархацтай малтмал ашиглаж, хууль бусаар олборлож байгаа үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын төлөвлөгөө 2019 онд 32.6 сая төгрөгөөр, 2020 онд 24.7 сая төгрөгөөр давж биелжээ. Аудитын баг Ихтамир, Булган суманд байршилтай элс, хайрганы карьер дээр очиж үзэхэд хяналт шалгалт хийсэн бүртгэлийн дэвтэр болон гэрээг гээгдүүлсэн, ашигт малтмалын олборлолт хийсэн аж ахуй нэгжийн бүртгэл тооцоо байхгүй зөвхөн камераар бүртгэлийг хийж төлбөрийг авдаг гэсэн боловч одоогоор камер нь эвдэрсэн, анхан шатны баримтаар хөтөлсөн бүртгэл тооцоогүй байв.

Эрдэнэмандал, Өндөр-Улаан сумын улсын байцаагч нар мод бэлтгэх эрхийн бичиг дээрээ байгалийн дагалдахын төлбөр гэж иргэдээс 920-2320 төгрөгийг хураан авч түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "орлогын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна. Эдгээр зөрчилтэй асуудлууд нь ашигт малтмалын төлбөрийн гүйцэтгэлд

³ 14.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 14.2-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.



холбогдох эрх бүхий байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох эрх бүхий байгууллагууд хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, МХГ, БОАЖГ-т хүргүүлэв.

Аудиттай холбоотой хэлэлцүүлэг, саналын талаар:



Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас “Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар илэрсэн асуудлууд, хуулийг хэрэгжүүлэн ажиллахад орон нутагт тулгарч буй хүндрэл бэрхшээл болон цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж ажиллалаа. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь нэг талаас орон нутгийн бодит нөхцөл байдалтай нийцдэггүй хүндрэлтэй асуудлууд байгаа талаар хэлэлцүүлэгт оролцогчид хэлж байлаа. **Тухайлбал:** Хуульд заавал хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж л ашигт малтмалыг олборлож, ашиглана, мөн тусгай зөвшөөрөлтэй

аж ахуй нэгжийн олборлож ашигласан, ачуулсан ашигт малтмалын борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцүү хэмжээгээр төлбөрийн орлогыг ногдуулна гэж заасан. Гэтэл сум, орон нутагт багахан хэмжээний элс, хайрганы карьерийг эзэмших өргөдөл хүсэлт ирдэггүй, ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа нь **хугацаа шаарддаг, өртөг зардал ихтэй** байдаг тул аж ахуй нэгжүүд зөвшөөрөл эзэмших сонирхолгүй байдаг нь хууль хэрэгжих нөхцөл боломж бүрдэггүй хууль зөрчигдөх асуудал гардаг. Иймээс хуулийг сум орон нутгийн бодит нөхцөл байдалтай нийцсэн хэрэгжихүйц байдлаар өөрчлөлт оруулж өгөх саналыг дэвшүүлж байсан тул аудитаас улсын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөөт аудит хийх саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- *Аймгийн ИТХ нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.*
- *Аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.*
- *Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжгүй тул төлбөрийг хуулийн дагуу ногдуулж, төвлөрүүлэх боломжгүй байна.*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.*



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Б.БАТЖАРГАЛД:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг тусгаж батлах, ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарган, хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг орон нутагт хэрэгжихүйц болгох асуудлын талаар тодорхой арга хэмжээ авч, холбогдох газарт уламжилж ажиллах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.БАТЖАРГАЛД:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүй олборлож, ашиглаж байгаа нийтлэг зөрчлийг таслан зогсоож, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход анхаарч ажиллах.
2. Хууль хэрэгжүүлэх эрх бүхий субъектүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр хураамжийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс орон нутгийн бодит нөхцөл байдалтай нийцдэггүй хүндрэлтэй байгаа асуудлын талаарх саналыг холбогдох газарт уламжилж ажиллах.
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын байдалд Байгаль орчны Улсын байцаагч нарын тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах чиглэлийг сумдын засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

АЙМГИЙН МХГ-ЫН ДАРГА А.ДАШХОРОЛД:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

АЙМГИЙН БОАЖГ-ЫН ДАРГА Г.АЛТАН-ОЧИРТ:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, эвдэрсэн газруудын нөхөн сэргээлтийг хийх арга хэмжээ авч ажиллах



2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг суурь тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөлтийг хийхэд анхаарч ажиллах.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын байдалд сумдын байгаль хамгаалагч нарын тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн хариуг **2022 оны 09 сарын 01-ний өдрийн дотор**
Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,
Утас/Факс: (976) 7033 3208,
И-мэйл: arkhangai.gov@gmail.com,
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

*Наадамдор
Б. Ойрууч
Башицзев
Б. Гүнх
Б/Х*

2021.10.12 № 01/1131
танай _____-ны № _____-т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт”-д (2019-2020он) хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан. Цаашид Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох талаар анхаарч ажиллах болно.



М.БАТЖАРГАЛ

05-141318



АРХАНГАЙ АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум
Утас/Факс: (976) 7033-2266,
И-мэйл: p_ar@inspection.gov.mn

2021-10-11 № 01/211
танай 2021.10.08 -ны № 342 -т

Тайлбар, санал хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын газраас "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай" хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараахи тайлбар саналыг хүргүүлж байна.

Уг тайлангийн 3.2.1-т "Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь Тариат сумын хүрмэн чулууны олборлолт ашиглалтаас бусад сумдын ашигт малтмал ашиглаж, хууль бусаар олборлож байгаа үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлээгүй байна" хэсэгт нэмэлт тайлбар гаргалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2019-2020 онуудад Тариат, Батцэнгэл, Эрдэнэбулган, Булган, Өндөр-Улаан, Цэнхэр сумдад түгээмэл тархацтай ашигт ашиглалтын байдалд шалгалт хийж, улсын байцаагчийн 8 заалт бүхий 3 албан шаардлагаар үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Мөн Эрдэнэбулган, Өндөр-Улаан сумдад 0,3 га талбайд нөхөн сэргээлт хийлгэсэн.

Аудитын зөвлөмжийн тус газарт хамаарах асуудалд тайлбар гаргах нь:

1. Тусгай зөвшөөрөлгүй хууль бусаар ашигт малтмал олборлож буй зөрчил нь эрүүгийн хэрэг учраас харьяалаалын дагуу Цагдаагийн байгууллагаар шийдвэрлэгддэг. МХГ нь ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд болон эвдэрсэн газрын нөхөн сэргээх арга хэмжээнд хяналт тавьж ажилладаг.

2. Аймгийн МХГ-аас сумдад ажиллах явцад холбогдох чиглэлийн байцаагч нар сүүлийн 2 жилд ковидын улмаас газар дээр нь ажиллах явцдаа сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр ханган мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

2019 оноос өмнө сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг жилд нэг удаа цуглуулан улсын байцаагч нарын зөвлөгөөн хийж мэдлэг мэргэжлийг дээшлүүлэн, ажлыг үнэлж дүгнэн арга зүйн тусламж дэмжлэг үзүүлж байсан болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А. ДАШХОРОЛ

0000273

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

1. Аймгийн МХГ-аас ирүүлсэн тайлбарт дурдсан сумдтай холбоотой хяналт шалгалт хийсэн баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй тул тайланд нэмэлт засвар хийгдээгүй болно.
2. Аудитын зөвлөмжтэй холбоотой 2 асуудлыг хүлээн авч тайланд тусгасан болно.